



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 30 өдөр

Дугаар АТ 230

Улаанбаатар хот

Дүүргийн өвөлжилтийн
бэлтгэл ажлыг хангахад шаардлагатай
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багахангай дүүргийн 2 дугаар хорооны 3, 4, 5, 6, 7, 8, 9, 12, 13, 16 дугаар байрнуудын хаалганы цоожийг солих, засварлах ажлыг зохион байгуулж уг ажилд шаардлагатай зардлыг санхүүжүүлэх арга хэмжээ авч, холбогдох тооцоог гаргахыг Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.

2.Засварын ажилд шаардагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталж, 6,721,000 (зургаан сая долоон зуун хорин нэгэн мянга долоо) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


3.Тус ажлыг зохион байгуулж дууссанаас хойш 14 хоногийн дотор үр дүнг эргэн танилцуулж, санхүүгийн тайланг ирүүлэхийг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг дүүргийн менежер (Г.Дагвадорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 10 дугаар сарын 20 ны өдрийн
8/230... дугаар захирамжийн хавсралт



ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн зардал	Нийт зардал
1	Соронзон мэдрэгчтэй цоож	ш	22	305,500	6.721,000
	Нийт дүн				6.721,000